

ЖИШЭЭ БАРИМТ АШИГЛАН, ДҮРСЛЭН
ТАЙЛБАРЛАЖ БИЧИХ

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

- Зохион бичих төлөвлөгөө гаргах
- Баримт мэдээллийг өөрийн сэтгэгдэл, уран дүрслэл, хэлц зэргээр баяжуулан дүрслэн тайлбарласан эх зохион бичих

БИЧИХДЭЭ ДАРААХ ЗҮЙЛИЙГ АНХААРАХ

- Хэнд зориулсан нь тодорхой байх
- Сонгосон амьтны онцлог шинж (нэршил, тоо толгой, амьдардаг газар, идэш тэжээл, авир араншин, ховордсон шалтгаан, эсвэл ашиг тус) зэргийг тодорхой харуулсан байх
- Сонгосон амьтны талаар 6-7 баримт, жишээ оруулсан байх
- “учраас, тул”, “иймээс”, “ийм учраас” зэрэг холбоос үг хэрэглэсэн байх;
- Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлсэн байх


1. СЭДЭВ СОНГОХ

- Өөрийн сайн мэддэг ховордож буй ан амьтан, жигүүртэн шувуудаас нэгийг сонгох
- Гарчиг болон сэдвээ тогтоох. Сонгосон сэдэв нь уншигчдын сонирхлыг татахаар, хэнд, юу хэлэх гэсэн санаагаа гаргасан байхыг анхаарах хэрэгтэй.

2. БИЧИХ ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХ


Төлөвлөгөө нь цуглуулсан мэдээллийг ангилж бүлэглэх, дэс дараалал, уялдаа холбоотой байх, зарим санааг давхардуулахгүй, орхихгүй байхад тустай.

Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт ямар мэдээллийг оруулахаа төлөвлөнө. Төлөвлөгөөг асуултаар, түлхүүр үгээр, богино өгүүлбэрээр бичиж болно.



3. СОНГОСОН СЭДВИЙН ТАЛААР СУДАЛГАА ХИЙЖ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ


- Сонгосон амьтны талаар ном, сурах бичиг, сонин, сэтгүүл, интернэтийн мэдээллийн сангаас унших, радио сонсох, телевизийн нэвтрүүлэг үзэх, орон нутгийн музей үзэх, бусдаас асууж лавлах зэргээр мэдээлэл цуглуулна. Ийнхүү мэдээллийг эрэл хайгуул хийх явцдаа бичихэд хэрэг болох чухал хэсгийг товч бичих, бүдүүвчээр зурах зэргээр тэмдэглэх. Өөрт төрсөн сэтгэгдлээ товч бичих. Уг зүйлийг баталж нотолсон үг, өгүүлбэр, тоо баримт зэргийг эхээс шууд хуулж авах



4. ЦУГЛУУЛСАН МЭДЭЭЛЛЭЭ АНГИЛЖ БҮЛЭГЛЭХ

Цуглуулсан мэдээллээс чухал ба чухал бусыг ялгах, дэс дараалалд оруулах. Эдгээр нь эхийн бүтцийг гаргах, бичих зүйлээ цэгцлэхэд тусалдаг.

• Оюуны зураглал хийх










Төлөвлөгөө	Холбогдох мэдээллийн гол санаа
Эхлэл	
Гол	
Төгсгөл	

5. ТӨЛӨВЛӨСНИЙ ДАГУУ БИЧИХ

- Зохион бичлэгийн эхний ноорог
- Эхийн эхлэл, төгсгөл болон гол хэсэгт ямар ямар санаа гаргахаар төлөвлөсөн, түүний дагуу санаагаа дэвтэртээ буулган бичих
- Зөв бичих дүрмийн алдаа, бичгийн хэв зэрэгтээ санаа зовох шаардлагагүй, хэлэх гэсэн гол санаагаа бичихэд анхаарах
- Дараа нь бичсэнээ уншиж, мартсан, буруу зүйл байгаа эсэхийг шалгаад нэмж, засаж бичиж болно.
- Бичиж дуусаад хэн нэгэнд уншуулж, эсвэл өөрөө түүнд уншиж өгөөд сайжруулах санал, зөвлөгөөг нь аваарай. Өөр хүнээс зөвлөгөө авч болно.

6. ЗОХИОСОН ЭХЭЭ САЙЖРУУЛАН БИЧИХ

- Бусдын өгсөн зөвлөгөөний дагуу эхийн агуулга, хэл найруулгыг, тухайлбал, илүү, дутуу бичсэн үг, өгүүлбэр, буруу бичсэн зүйл байвал засаарай.
- Зөв бичих дүрмийн алдаа байгаа эсэхийг хянаарай. Эхийн алдааг засахдаа үг, бүтээвэр, үсэг нэмэх, хасах, солих зэргийг тэмдэглэдэг тусгай тэмдэглэгээ ашиглаарай .
- Эхийг сийрүүлэн бичнэ. Эхийн утгыг тодруулсан зураг, бүдүүвч зэргээр баяжуулж болно.

Алдаа	Засвар	Тэмдэглэгээ
Үсэг, бүтээвэр, үг, өгүүлбэр дутаасан	Нэмэх, оруулах	
Үсэг, бүтээвэр, үг, өгүүлбэр илүү бичсэн	Хасах	
Үсэг, үг, өгүүлбэрийг буруу байрлуулсан	байр солих (зэрэгцээ бол)	
	Шилжүүлэх (хол зайтай бол)	
Үг нийлүүлж бичсэн	Салгах	
Үг салгаж бичсэн	Нийлүүлэх	
Догол мөр гаргаагүй	Догол мөр гаргах	

Мазаалай бол дэлхийд ховордсон амьтан

Мазаалайн тухай бичье гэдэг бодвол санаанд оруу ч орсонгүй. Яагаад Хятадын Сычуань мужид байдаг хулсны баавгай, Арктикийн цагаан баавгайн тухай мэддэг атлаа зөвхөн манай говьд л байдаг, "Улаан нам"-д орсон мазаалайн тухай мэддэггүй билээ? Энэ үед өөрийгөө их л голж байсан ч "Монголоо мэддэггүй монгол" гэдгээ өйлөгсөндөө л байрлааж байлаа.

Бид биологийн хичээлээр сүүгээр байжигн, мөлхөгч, хоёр нутагтны тухай ганц нэг хэлэх юмтай атлаа мазаалайн тухай ховор амьтан гэдгээс өөр төсөөлөлгүй. Газар зүйн хичээлээр "Дэлхийн дархан цаазтай газар"-ыг судалсан атлаа өөрийнхөө улсын дархан цаазтай газрын тухай, хаагуур ямар амьтан, ургамал тархсан байдгийг оет мэддэггүй явж байгаа нь үнэхээр харамсалтай байгаа биз.

Хятад улс пандагаа устгаж үгүй болгохоос нь өмнө аварч чадсан. Тэр бүү хэл 2008 онд хулсны баавгайг Бээжингийн олимпын бэлгэ тэмдэг болгож, дэлхий нийтэд таниулаж чадсан. Ховордсон ан амьтны төлөөлөл болсон энэ амьтан "хөгжим баясал, хайр эвэрийлэл"-ийг бэлэгдсэн.

Тэгвэл бид яагаад Ази тивийн аварга шалгаруулах аль нэгэн тэмцээн уралдаан зохион байгуулахдаа мазаалайг бэлгэ тэмдэг болгож болохгүй гэж?

БНХАУ-ын айдарт зураач Ша Ма Ла И манай оронд ирээд уран зургийн галерейд үзэсгэлэн гаргасныг би сайн санаж байна. Нийт 65 бүтээлийнх нь 50 хамталах сэтгэлийг уран бүтээлээрээ дамжуулан хүүрлүүдэг. Би хөгжим мазаалайн тургаар уран бүтээлийн үзэсгэлэнгээ гаргах байна" гэж сэтгүүлчдэд ярилцлага өссөн байсан. Эх орны маань ховор амьтныг гадны зураач зураад, үзэсгэлэнгээ гаргачихвал ичгэвтэр юм болох биз.

Бр нь мазаалайн тухай таниулаж чадах эл хүмүүс баг захиалч, эрдэмтэн, судлаач, уран бүтээлч, хөгжмийн зохиолч, зураач нар юм. Тэд мазаалайн тухай бүтээл туурвиж болно. Бид ч зүгээр сууж болохгүй мазаалайг хамгаалах үйл ажиллагаанд чадлынхаа хэрээр оролцох боломжтой. Шинэ жилийн баяраар "Улаан нам"-д орсон амьтдын дүр бүтээж, бүжиглүүлж болно. Дүрсгэх урлаг, технологийн хичээлээр ховор амьтдыг зуруулж, баг хийлгэж болно. Хүүхдүүд бид чинь хийж бүтээсэн зүйлээ илүү сайн ойлгож, бас хайрлаж чаддаг билээ. Энэ бүхэн мазаалайн тухай мэдлэгтэй болж, түүнийг хайраар хамталах үндэс болно. Цөөхөн үлдсэн энэ амьтан монгол хүн бүрийн хайраар тэжээгдэн өсөж үржин, олон балах цаг тун удахгүй биз ээ.

(Сурагч Г. Түвшинжаргал)

Сурагчийн бичсэн "Мазаалайг хамгаалахад миний оролцоо" эхийг доорх шалгуураар үнэлье.

- Бичигч мазаалайг хамгаалах үйл ажиллагаанд яаж оролцсон талаар тайлбарласан хэсэг байна уу?
- Мазаалайг яагаад, ямар учраас хамгаалах вэ? Үүнийг нотолсон баримт, тайлбар байна уу?
- Мазаалайг сурталчлан таниулах шаардлагатай гэдгийг тайлбарласан уу?
- Бичигч мэдрэмж, сэтгээгдэл, үзэл бодлоо илэрхийлсэн үү?

Анхаарал тавьсанд баярлалаа.